

LINGUISTICS AND LITERATURE
Institute of Language and Literature
Mongolian Academy of Sciences

Tom. 1 (33)

2008

Fasc 8

БИГЭРИЙН ЭРТНИЙ БИЧЭЭСҮҮД

Ц.БАТТУЛГА

Улаанбаатар

Тулхуур үгс: Түрэг бичээс, Бигэрийн бичээс, Говь-Алтай аймгийн Бигэр сум

Говь-Алтай аймагт хийсэн хээрийн судалгаа шинжилгээний ажлын үр дүнд эртний үсэг бичгийн хэд хэдэн дурсгал шинээр олж илрүүлсэн билээ. Энэ удаад судалгааны эргэлтэд орж олны сайн мэдэх болсон “Бигэрийн бичээс”-ийг дахин нягталсан хийгээд мөн газраас шинээр илрүүлсэн бичээсийг уншиж тайлснаа товч өгүүлье.

Бигэрийн эртний бичээс нь Говь-Алтай аймгийн Бигэр сумын төвөөс баруун урагш 17 км-т, Хар ааргийн бууц, Хар ааргийн бичигт бууц, Бичигтийн бууц хэмээн нутгийнхан өөр өөрсдийнхөөрөө нэрлэх, энгэр талдаа хад цохиотой бэсрэг толгойн өврийн өвөлжөөний хаданд байдаг.

Өндөр уулын бэлийн энэхүү өвөлжөө болон түүнээс баруун, зүүн зүг үргэлжлэх аараг толгод нь өвөрмөц, гялалзсан хар, хар хүрэн өнгийн хүрмэн чулуун тогтоцоороо эргэн тойрны уулсаас ялгаран онцгойрч харагдах тул “Хар аараг” хэмээн нэрлэсэн бололтой. Аараг толгод нь хадны зургаар нэн арвин бөгөөд үүнээс улбаалан нутгийн ардууд “Бичигт” хэмээн нэрлэх болсон байна. Учир нь Монголчууд зөвхөн эртний үсэг бичигтэй бус хадны зураг ихтэй, элдэв зүйл тамга тэмдэг цохисон хад чулуутай газрыг “Бичигт” гэж нэрлэдэг уламжлалтай холбоотой.

Бэгэр* буюу Бигэрийн эртний бичээсийг Монгол-Зөвлөлтийн хамтарсан түүх соёлын шинжилгээний ангийн “Бичээс судлал”-ын хэсэг 1969 онд анх олж илрүүлжээ¹. Уг бичээсээс дөрвийг нь түрэг судлаач М.Шинэхүү гуай тайлан уншиж² үсэг, үгийн галигийг хийж бичээс тус бүрийн утгыг монгол бичгийн хэл болоод хасаг, манж хэлнээ харгуулан орчуулж хадсан бөгөөд эрдэм шинжилгээний ном бүтээлүүдэд түүний судалгааг гол эх хэрэглэгдэхүүн, тулгуур сурвалж болгон ашигласаар ирсэн байна³.

М.Шинэхүү гуайн нийтлүүлсэн гар хуулбар, уншлага судалгаа нь бодит эхүүдээс багагүй зөрүүтэй байсан тул “Бигэрийн бичээс”-ийн талаар дахин

* Уг бичээсийг анх тайлж уншсан М.Шинэхүү гуай “Бэгэр” хэмээн нэрлэжүүхүй.

1. М.Шинэхүү, Бэгэрийн эртний түрэг бичээс, -Шинжлэх Ухааны Академийн мэдээ, Улаанбаатар, 1971, №1, 37-39 дугаар тал.

2. М.Шинэхүү, Бэгэрийн эртний түрэг бичээс, -Шинжлэх Ухааны Академийн мэдээ, Улаанбаатар, 1971, №1, 37-39 дугаар тал.

3. Д.Дашбадрах, Бигэрийн түрэг бичээс, -Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал (сэдэвчилсэн лавлах), Улаанбаатар, 1999, 205 дугаар тал.

өгүүж байна. Бичээсүүдийг М.Шинэхүү гуайн анх нийтлүүлсэн дарааллыг баримталж дугаарласан болно.

Нэгдүгээр бичээс

Бигэрийн нэгдүгээр бичээс нь Хар ааргийн “Бичигтийн бууц”-ны өвөлжөөний баруун хойт талын хаданд буй. Хадны өнгөн хэсгийн хар хүрэн тогтоц үсэг тэмдэгт цохихын хэрээр холцорч цайвар өнгө гарснаас бичээс маш тод, хэдэн алхамын цаанаас ч харагдах ажээ.

Найман үсэг тэмдэгтээс бүрдэх эл бичээсийг буулгахдаа ташаа хуулж сийрүүлснээс өмнөх судалгаа мадагтай болжээ. Тиймээс бичээсийг шинээр уншиж судалснаа толилуулж буй бөгөөд эрдэмтэд харьцуулан үзэх, дахин нягтлан судлахад тустай хэмээн санаж М.Шинэхүү гуайн судалгааг ч бүрэн эхээр нь орууллаа.

М.Шинэхүү гуайн судалгаа:

Бичээс № 1

Handwritten Mongolian script of the inscription, showing two lines of text: "UÇURLR JOLĪ ARTURDA" and "UÇARLAR JOLĪ ARTURDA".

Галиг:

U Ç U R L R J O L Ī A R T U R D A

Тоймлон уншсан нь:

Эртний түрэг: UÇURLAR JOLĪ ARTURDA

Монгол бичгийн хэл: UÇARAγSAD JAM (DUR) ARBIJIBA (NEMEGDEBE)

Хасаг: OÇARLAR JOLDA ARTARDĪ

Манж: UÇARA JÜGÜN хэмээжээ.

Тэрбээр бичээсийг монгол хэлнээ “Учрагсад замд арвижив (нэмэгдэв)” гэж орчуулсан байна.

Проф. Л.Болд энэ бичээсийн тухайд “Одоогоор бидний гар дээр уг бичээсийн талаар өөр ямар нэгэн эх байхгүй байгаа учир энэ үгчилсэн буулгалтын талаар үг хэлэхэд ихээхэн бэрхшээл учруулж байна. Тийм хэдий боловч зохиогчийн өөрийн хийсэн үгчилсэн буулгалт, мөн орчуулга хоёрын хооронд бага боловч зөрүү байгааг тайлбарлан хэлэх хэрэгтэй байна. Тухайлбал нэгдүгээр бичээст буй йолы гэдэг үг бол йол “зам” гэдэг үгийг гуравдугаар биед хамаатуулсан хэлбэр юм. Иймд энэ мөрийг учирагсадын зам нь холдоо буюу эсвэл учрах зам нь уртаслаа гэсэн хэлбэрээр орчуулах байжээ”⁴ хэмээжээ.

⁴ М.Шинэхүү, Бэгэрийн эртний түрэг бичээс, -Шинжлэх Ухааны Академийн мэдээ, Улаанбаатар, 1971, №1, 37 дугаар тал.

⁵ Л.Болд, БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 22 дугаар тал.

Уг бичээсийн талаар өөр судалгаа, санал энэ хир хараахан гараагүй ажээ.

Бичээсийг газар дээр нь очиж үзэхэд үсэг тэмдэгтийг нилээд зөрүүтэй буулгасан болох нь тодорхой харагдаж байна. Үүнд, бичээсийн хоёрдугаар мөрийн эхний үсгийг нэгдүгээр мөрийн эхний үсэг хэмээн ташаарсан, хоёрдугаар мөрийн эхний $\lambda(W)$ -г $\downarrow(a)$, мөн мөрийн зургаадугаар үсэг болох $\downarrow(Q)$ -г $\downarrow(R)$ гэж ташаарчээ.

Бидний судалгаа

Бичээсийн эхийн сийрүүлгэ

		$\downarrow \downarrow \downarrow \downarrow \downarrow \downarrow \downarrow$ $\downarrow \downarrow \downarrow \downarrow \downarrow \downarrow \downarrow$
Үсгийн галиг;	Үгийн галиг;	Үгчилсэн орчуулга;
εWRηR YWLι WLRTWQDa	εur aηar yoli olurtuqda	Чур түүнд зам нь бүхүйд

Эл бичээсийн үргэлжлэл нь хоёрдугаар бичээс тул нийлж байж бүрэн утга илэрхийлж байгаа болно.

Хоёрдугаар бичээс

Хоёрдугаар бичээсийг нэгдүгээр бичээсийн доор залгуулан хурц үзүүртэй зүйлээр зурчиж бичжээ. Олон дахин зурчилгүй шууд бичсэн нь нэгд, багаж зэвсэг нь маш хурц, үзүүр ир сайтай байсныг, хоёрт, бичээч тун чадварлаг нэгэн болохыг илтгэж байна.

М.Шинэхүү гуайн судалгаа:

Бичээс № 2

Н Ж В Х Ү Л Д

Галиг:

B L I L D K M Z

Тоймлон уншсан нь:

Эртний түрэг: BALA ĀDIKMĀZ

Монгол бичгийн хэл: BARLUҮ IL (EL IRGEN) AČILAYSAN
(TUSALAYSAN ÜGEI) ÜGEI

Хасаг: MALAI (JALČI) EL ISIMIZ

Орчин цагийн монгол хэл: Барлаг ил (эл иргэн) ачилсангүй (тусалсангүй)

М.Шинэхүү гуай уг бичээсийн манж орчуулгыг хийсэнгүй бөгөөд хоёрдугаар үсэг $\downarrow(\eta)$ -ийг $\downarrow(L)$ хэмээн ташаарснаас уншлага судалгаа мадагтай болжээ.

Бидний судалгаа

Эхийн сийрүүлэг;
Чᠡᠬᠡᠪᠠᠶ᠋ᠠᠨ

Үсгийн галиг;
b ɣ i l d[ˈt] ʊk m z

Үгийн галиг;
bāji eld[ˈt]ʊkmāz

Орчуулга:

Намайг илгээхгүй (намайг явуулахгүй)

Нэг, хоёрдугаар бичээсийг нийлүүлбэл:

Чᠡᠬᠡᠪᠠᠶ᠋ᠠᠨ ᠵᠢᠨᠭᠡᠨᠠᠵᠠᠷ ᠶᠣᠯᠢ ᠣᠯᠣᠷᠲᠤᠴᠠᠳᠠ ᠪᠠᠩᠵᠢ ᠡᠯᠳ[ˈt]ʊkmāz

Үгчлэн буулгавал: Чур түүнд зам нь бүхүйд намайг илгээхгүй

Утгачилан орчуулбал: Чур тийшээ (тэр зүг) явах зам бүхүйд намайг явуулсангүй.

Үүнээс үзэхэд Чур цолтой нэгэн зам байсаар атал эл бичээсийг бичигчийг явуулаагүйг онцлон тэмдэглэсэн бололтой.

Гуравдугаар бичээс

М.Шинэхүү гуайн судалгаа:⁶

Бичээс № 3.



Галиг:

K Ö L G N I J O R T I

Тоймлон уншсан нь:

Эртний түрэг: KÖLÜG NI JORTI

Монгол бичгийн хэл: KÖLÜG INU JORČIBA (YABUBA)

Хасаг: KÖLIK (NI) JÜRDI

Манж: KÖLÜY INI (NINGGE) JÜRAMBİ

Орчин цагийн монгол хэл: Көлөг нь зорчив

Уг бичээсийн тухайд академич Л.Болд “Күлүг гэдэг үг нь угтаа кү “алдар, гавьяа” гэсэн үгэнд лик гэсэн дагавар залгаж бүтээсэн үг, энд алдарт (баатар) явлаа гэсэн утгаар орсон байна” хэмээн тэмдэглэжээ.⁷

⁶ М.Шинэхүү, Бэгэрийн эртний түрэг бичээс, -Шинжлэх Ухааны Академийн мэдээ, Улаанбаатар, 1971, №1, 38 дугаар тал.

⁷ Л.Болд, БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 22 дугаар тал.

Бидний судалгаа

Бичээсийн эхийн сийрүүлэгэ;

ᠮᠠᠨᠪᠢᠳᠢᠬᠡᠢ

Орчуулга

Күлүг түүнийг явуулав

Үсгийн галиг;

k u l g N I Y W R T i

Үгийн галиг;

külüg anᠢ yor(t)ᠢᠮ

Дорөвдүгээр бичээс

М.Шинэхүү гуайн судалгаа:

Бичээс № 4.

ᠮᠠᠨᠪᠢᠳᠢᠬᠡᠢ

Галиглан буулгасан нь;

MN BITP

Тоймлон уншсан:

Эртний түрэг: MĀN BĪTP

Монгол бичгийн хэл: MA (BI, BA) BIČIB (E)

Хасаг: MĀN BITP

Манж: BI BIDXE хэмээн

Орчин цагийн монгол хэл: Би бичив [Ma (би, ба) бичив]

Бичээсийг уг эхтэй харьцуулж үзэхэд мөн л алдаатай хуулбар эх, судалгаа болжээ. Жишээ нь бичээсийн эхэнд “» m” байхгүй атал “) (N) > (W)” үсгүүдийг нийлүүлж “» m” үсэг хэмээн ташаарчээ. Бичээсийн төгсгөлийн “* b” үсгийг “* t”, “t j” үсгийг “t p” хэмээн андуу буулгасан байна.

Бидний судалгаа

Эхийн сийрүүлэгэ;

ᠠᠨᠨᠪᠢᠬᠡᠢ

Үсгийн галиг;

N N B i b j

Үгийн галиг;

anᠨ abᠢ biᠭ

Үгчилсэн орчуулга;

Түүний ан нь мянга

Авлаар ирэгсдээс анч нэгний авласан ан нь бусдаас илүү олон байсныг онцлон дуртаж “Түүний ан нь мянга” хэмээн ганц мөр үгээр илэрхийлсэн, эсвээс “түүний” гэдэг нь энэ газар нутгийг зааж буй хэмээн үзвээс “Энэ газрын ан ав мянга” буюу энэ газар, нутагт ан ав арвин байгааг онцлон тэмдэглэсэн байж болно.

Тавдугаар бичээс

Бичигтийн бууцны зүүн өмнө талын хаданд буй шинээр олдсон эл бичээс ганц мөр байсан бололтой, эхний үсгүүдтэй хад хагарч унаснаас зөвхөн гурван үсэг л үлджээ.

Бичээсийн эхийн сийрүүлэг; HФХ ...	Үсгийн галиг; ...GYQ	Үгийн галиг; ...γ ауқа	Орчуулга; ...-ыг сард
--	-------------------------	---------------------------	--------------------------

Үлдсэн гурван үсгийн "... сард" хэмээн тоймлон уншиж болох ба бичээсийн утгын талаар өгүүлэх боломжгүй юм.

Зургаадугаар бичээс

Шинээр олсон уг бичгийн дурсгал нь гурван үсэг тэмдэгтээс бүтэх ганц мөр юм. Зураасан (хялгасан) бичиг тул сайн эс ажиглаваас олж үзэхэд нэн бэрхтэй.

Бичээсийн эхийн сийрүүлэг; »JД	Үсгийн галиг; Y L m	Үгийн галиг; yalim	Орчуулга; 1.эгц, цавчим
--------------------------------------	------------------------	-----------------------	----------------------------

yalam (yalma) 2.дээл, хуягт дээл

Бичээсийн эхний нэг үгийг бичээд дутуу орхисон бололтой. Энэ үг 1. эгц цавчим хад хясаа, 2. дотуураа ялтсан хуягтай арьсан дээл гэсэн утгатай байж болох юм.

Долоодугаар бичээс

Толигор хадан дээр руни бичгийн хоёр үсгийг маш гаргацтай тод цохиод дутуу орхижээ. Бид нэгэнт Бичигтийн бууцын хэсэг бусад руни бичгийг толилуулж буй тул хэдийгээр хоёрхон үсэг ч гэлээ "Долоодугаар бичээс" хэмээн оруулав.

Монголын руни бичгийн, нэн ялангуяа бага бичгийн дурсгалын бүртгэлийг гаргах, хэсэг бусад бичээсийн онцлог, учир шалтгааныг тодруулан судлахад эх хэрэглэгдэгдэхүүн болох буй за.

Бичээсийн эхийн сийрүүлэг; Hl	Үсгийн галиг; s Q	Үгийн галиг; esqa[~ešqa]
----------------------------------	----------------------	-----------------------------


Орчуулга;
андад, нөхөрт

Бигэрийн Хар аарагийн Бичигт бууцны эдгээр бичээс ганц, нэг мөр, цөөн хэдэн үгээс бүтэж байгаа хэдий ч эртний түрэг хэлний баримт, руни бичиг судлалын эх хэрэглэгдэхүүн болохын хувьд үнэ цэнэтэй юм.

Хавсралт



Бичигтийн бууц



Нэгдүгээр бичээс

SUMMARY

As a result of the field research and survey that had been conducted within the frame of the project "Research on the Ancient inscriptions in Gobi-Altai province", some ancient inscriptions were found.

This time we carefully checked the readings of "The Inscriptions from Biger" which was already familiar to the reseachers. Also, we found and read some new inscriptions in that site. Ancient inscriptions from Biger are mostly on the rocks of the hills which the local people call differently as 'Khar aargiin buuts', 'Khar aargiin bichigt buuts', or 'Bichigtiin buuts'. The hills are 17 km far away from Biger district of Gobi-Altai province to the south west. The name "Khar aarag" is originated from its special formation. There are numerous rock paintings. That's why this place was named after 'Bichigt'.

Ancient inscriptions from Biger were discovered by the Mongol-Soviet co-expe-dition of history and culture in 1969. A turkologist M. Shinekhuu read and explained the inscriptions for the first time and his research materials has been used in the sci-entific works of the Mongolian Runic script until recent time.

First inscription

First inscription from Biger is located on the north-western rock of Bichigt wintercamp in Khar aarag and it was written superficially. It is very clear to read because the letters and other marks are wide and broad so that they could be seen in distance of few steps.

First inscription consists of two lines and each has the similar eight marks.

In our opinion first research has some errors for the reason than the letters and script of the inscription were copied out inaccurately. Therefore we made an effort to investigate and read thoroughly.

We noticed and found out some mistakes of the letters and words in the copy, as we came to the site and read the inscription.

Our research.

Copying out from the inscription:

ᠨᠢᠳᠬᠠᠷᠠᠭᠢᠨ

ᠪᠢᠴᠢᠭᠲᠢᠨ

Transcription of the letters.

čWRᠠᠷ YWLᠢ

WLRTWQDa

Transcription of the words.

čur a᠋ᠨᠠᠷ yoli

olurtuqda

Translation:

Chur, he has apath

Second inscription

Second inscription was written followed by 1st inscription by using sharp tools. It indicates writer's skill, too.

Our research.

Copying out from the inscription:

Чᠡᠪᠬᠡᠶᠡᠨᠠᠭᠤ

Transcription of the letters.

b ᠡ ᠶ ᠡ ᠨ ᠠ ᠭ ᠤ

Transcription of the words.

bāᠡᠨi elᠨ[-t]ükᠮᠠᠵ

Translation:

Didn't make me go there

Doesn't pick me up, don't allow me to follow ...

Намайг илгээхгүй (намайг явуулахгүй)

If we combine the 1st and 2nd inscription, we can get the following;

Чᠡᠪᠬᠡᠶᠡᠨᠠᠭᠤ ᠶᠡᠨᠠᠭᠤᠯᠠᠷᠲᠤᠭᠠᠳᠠᠨᠠᠭᠤᠯᠡᠳᠡᠨᠠᠭᠤᠯᠡᠭᠡᠮᠠᠵ ᠶᠡᠨᠠᠭᠤᠯᠠᠷᠲᠤᠭᠠᠳᠠᠨᠠᠭᠤᠯᠡᠳᠡᠨᠠᠭᠤᠯᠡᠭᠡᠮᠠᠵ

Translation: Chur, he has apath, but didn't send me

Third inscription

Our research.

Copying out from the inscription:

ᠬᠤᠯᠤᠭᠠᠨᠢᠶᠣᠷᠲᠤᠭᠢ

Transcription of the letters.

k ᠤ ᠯ ᠤ ᠭ ᠠ ᠨᠢ ᠶ ᠣ ᠷ ᠲᠤ ᠭᠢ

Transcription of the words.

külüg anī yor(t)ᠭī

Translation: Kulug made him/her go

Fourth inscription

Our research.

Copying out from the inscription:

ᠶᠡᠨᠠᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ

Transcription of the letters.

ᠶ ᠡ ᠨ ᠠ ᠨ ᠠ ᠭ ᠤ ᠯ ᠠ ᠭ ᠤ ᠨ

Transcription of the words.

anīn abī biᠭ

Translation:

“Its hunting was in thousands”, may be it said that someone’s hunting was more and abundant than those of the others. Or, in other words, let’s consider the word “its”. If we think “it”, he noted that the areas full of wild beats by saying that “Its hunting was in thousands”.

Fifth inscription

Fifth inscription included just 3 words, because the rock was broken. It’s in the south-east of the Bichigt buuts.

Our research.

Copying out from the inscription:

ᠠᠳᠤᠰ ...

Transcription of the letters.

...GYQ

Transcription of the words

...γ ayqa

Translation:...in/of month

It's impossible to explain the meaning.

Sixth inscription

This inscription has one line that includes 3 marks. Writing is very thin. Therefore it's difficult to read and can not be read if we don't pay careful attention.

Our research.

Copying out from the inscription:

ᠶᠯᠮ

Transcription of the letters.

Y L m

Transcription of the words.

yalim

/yalam (yalma)/

Translation: 1.straight, steep

2.garment, armoured garment

The writing was uncompleted from any reasons. We read just few words by versions.

1st: sharp and sraight cliff.

2nd: skin garment which has plated armour inside of it.

Seventh inscription

Two runic letters were written on the smooth rock. We think it was incomplete.

Since we are presenting all part of runic inscriptions of Bichigt buuts for careful consideration, those 2 letters was named as the 7th inscription. Probably, it would be mostly used for making clear registration of Mongolian runic script, especially minor scripts, as well as studying the specific features and reasons of all scripts.

Our research.

Copying out from the inscription:

ᠰᠠ

Transcription of the letters.

s Q

Transcription of the words.

esqa [-esqa]

Translation:

to friend / to companion

Although the inscriptions in Bichigt buuts of Khar Aarag in Biger consist of a few words and lines, it's expensive since these are important facts of ancient turkish language and important source materials for the runic studies.